

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН “ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН  
АЖИЛТНЫ ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ӨНГӨ, ЯЛГАХ ТЭМДЭГ, ДҮРЭМТ ХУВЦАС ӨМСӨЖ  
ХЭРЭГЛЭХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” ТУШААЛЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2023.04.17

Улаанбаатар

ХОТ

№	Нөлөөллийн шинжилгээний асуулт	Хариулт	Тайлбар
1	Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилт	<p>Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Дүрэмт хувцасны загвар болон ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллага тогтооно.” гэж заасан нь энэхүү “Журмыг шинэчлэн батлах тухай” тушаалыг батлах эрх зүйн үндэслэл болно.</p> <p>Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зааснаар Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 126 дугаар тушаалаар “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ыг баталсан.</p> <p>Өнөөгийн цаг үе, нийгмийн байдалд нийцүүлэн гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын алба хаагчдын дүрэмт хувцас, ялгах тэмдгийг уул уурхай, оффис, үзвэр, үйлчилгээ, банкны, барилга байгууламжийн хамгаалалт гэсэн төрлүүдээр өөрчлөн шинэчлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага бий болсон.</p> <p>Иймээс Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 126 дугаар тушаалаар баталсан “Гэрээт харуул, хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ыг шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, санал, дүгнэлт гаргах, төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/164 дүгээр тушаалаар байгуулагдсан.</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн 10/04 дугаарын албан бичгээр тушаалын төсөлд санал авахад нийт 16 байгууллага саналгүй, 7 байгууллагаас 12 санал тус тус ирүүлснийг нэгтгэн, тушаалын төслийг боловсруулсан.</p> <p>Гэрээт харуул хамгаалалтын ажилтны эрх зүйн байдал, түүнд хяналт тавих цагдаагийн байгууллагын хоорондын харилцааг зохицуулахад оршино.</p>	

2	Актын зохицуулах харилцаа, хамрах хүрээ, ерөнхий бүтэц	<p>Цагдаагийн ерөнхий газрын даргын “Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаалын бүтэц:</p> <p>Нэг.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын ажилтны дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа”-г нэгдүгээр, “Ялгах тэмдэг, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсан тухай;</p> <p>Хоёр. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>Гурав. Тушаал гарсантай холбогдуулан өмнөх тушаалыг хүчингүй болсон тухай;</p> <p>Дөрөв.Тушаалыг мөрдөж эхлэх хугацаа.</p>	
3	Акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох	<p>Тушаалын төслийг Цагдаагийн ерөнхий газрын цахим хуудас /www.police.gov.mn/-ын “Хууль, эрх зүй” булангийн “Хэлэлцүүлэг”-т 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдөр байршуулж, иргэдээс санал авах ажиллагааг зохион байгуулахад нийт 428 хандалт хийгдэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс санал ирээгүй бөгөөд</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2023 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн 10/04 дугаарын албан бичгээр тушаалын төсөлд санал авахад нийт 16 байгууллага саналгүй, 7 байгууллагаас 12 санал тус тус ирүүлснийг нэгтгэн, тушаалын төслийг боловсруулсан.</p> <p>Нийт 102 гэрээт харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллага, 4 холбоодоос харуул, хамгаалалтын байгууллагуудын ажилтан, алба хаагчдын дүрэмт хувцсыг өөрчлөн шинэчлэх талаар 23 аж ахуйн нэгж, 4 холбоодоос санал ирүүлснийг төсөлд тусгасан.</p>	
4	Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх	<ul style="list-style-type: none"> <li>• Хүний эрх, эрх чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх - үгүй</li> <li>• Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх – нийцсэн</li> <li>• Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх – эрх тэгш байдал хөндөгдөхгүй</li> <li>• Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх - үгүй</li> <li>• Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх - үгүй</li> <li>• Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх - үгүй</li> </ul>	

		<ul style="list-style-type: none"> <li>• Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж, байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх - үгүй</li> <li>• Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх - үгүй</li> <li>• Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх – үгүй</li> <li>• Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх - үгүй</li> </ul>	
5	Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2008 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 126 дугаар тушаалаар “Гэрээт харуул хамгаалалтын байгууллагын алба хаагчдын дүрэмт хувцасны загвар, өнгө, материалын ялгаа, дүрэмт хувцас өмсөж хэрэглэх журам”-ыг баталсан.	
6	Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо	Гэрээт харуул хамгаалалтын тухай, цагдаагийн албаны тухай хуулийн хэрэгжилт хангагдах боломж бүрдэнэ. Шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй.	